

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ 2016 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Агуулга	Хийх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн	Биелэлт
Нэг. Хуулиар хүлээсэн үүргийн биелэлт					
1.	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаархи мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах	1.1.Сурталчилгааны материал боловсруулж, түгээх	Жилийн турш	ЭБАТ	
		1.2. Авлигатай тэмцэх газраас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материалыг иргэд, байгууллага, албан хаагчдад түгээх, бүртгэл хөтлөх /бүртгэлийг тайланд хавсарган АТГ-т хүргүүлэх/	Жилийн турш	ЭБАТ	Авлигатай тэмцэх газраас бэлтгэн ирүүлсэн “Мэдүүлэг гаргагчдад зориулсан гарын авлага, бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдлын судалгаа, АТГ.мон сэтгүүл, зурагт хуудас, сурталчилгааны материал”-уудыг яамны албан хаагчдад тараасан.
2.	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох	2.1.Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг цахим хуудсаар хүлээн авах боломжийг бүрдүүлэх	Жилийн турш	ЭБАТ	Яамны цахим хуудсанд боловсруулж байгаа дүрэм, журмын төслийн тухай бүр нь байршуулж, цахимаар болон бичгээр санал авч байна. /Эхлэл/Баримт бичгүүд/Боловсруулж буй эрх зүйн актууд/ http://mcud.gov.mn/documents/
		2.2.Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг тус бүр цахим хуудсандаа байршуулсан байх	Жилийн турш	ЭБАТ, БНААБГ, БЧААБГ, СБТГ, ХБГХБГ	Барилгын тухай хуулийг дагалдан батлагдах дараах дүрэм, журмуудын төслийг яамны цахим хуудсанд байршуулсан. Цахимаар болон бичгээр санал авч ажиллаж байна. - Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм - Барилгын ажлын захиалагчийн дүрэм - Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм - Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм - Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм - Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх экспертэд тавих шаардлага, түүнийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, эрх олгох журам - Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журам - Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм - Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдэд тавих шаардлага, хэрэгжүүлэх,

					бүртгэх журам Туршилт, шинжилгээ судалгааны ажил эрхлэх нэгдсэн лабораторийн дүрэм
	2.3.Дээрх асуудлаар иргэд, олон нийт, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох, саналыг хэрхэн тусгасан талаар нотлох баримтыг тайланд хавсарган АТГ-д хүргүүлэх	Жилийн турш	ЭБАТ	Барилгын тухай хуулийн дагуу Засгийн газраар батлуулах 6 дүрмийн төсөлд сонирхогч бүлгүүд, салбарын төрийн бус байгууллага, судлаачдыг оролцуулан 4 удаа хэлэлцүүлэг зохион байгуулсан. Яам, төрийн бус байгууллагуудаас журам, дүрэмд ирүүлсэн саналыг товъёогыг хавсаргав.	
	2.4. Яам, харьяа байгууллагуудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж иргэдэд хүндрэл чирэгдэл учруулж буй дүрэм журмыг боловсронгуй болгох	Жилийн турш	ЭБАТ	Монгол Улсын барилгын салбарт өнгөрсөн 80 гаруй жилийн хугацаанд ЗХУ /хуучин нэрээр/-ын дүрэм, норм норматив, стандартыг мөрдөж ирсэн бөгөөд сүүлийн үед барилгын үйлдвэрлэлд шинэ дэвшилтэт техник технологи ихээр нэвтэрч байгаатай уялдуулан барилгын салбарын норматив баримт бичгийг шинэчлэх, гадаад улсын барилгын дүрэм, стандартыг хүлээн зөвшөөрч, хэрэглэх асуудал тулгамдаад байна. Барилга байгууламжид төлөвлөлтийн норм дүрмийн дагуу шаардлагатай хэмжээтэй газар олгогдохгүй байгаагаас үүдэн дараах хүндрэл бэрхшээлүүд тулгараад байна. Үүнд: - Барилгын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж, материал байрлуулах талбай хангалтгүй байх; - Барилгын ажил гүйцэтгэх явцад нийтийн болон гуравдагч этгээдэд аюул учруулах нөхцөл бололцоо бүрдэх; - Барилга байгууламжийн хоорондын зай талбайн зохистой хэмжээ алдагдаж, нийтийн зам талбай, зорчих хэсгийн хөдөлгөөн хязгаарлагдах гэх мэт; Барилга байгууламж барих, барилга байгууламжийг ашиглалтад оруулах, цаашлаад барилга байгууламжид гэрчилгээ олгох, ашиглах, буулгахтай холбогдсон харилцааг зохицуулах, зохих зөвшөөрөл олгоогүй байхад барилгын ажлыг дур мэдэн эхлүүлэх, чанар аюулгүй байдлын болон төлөвлөлтийн шаардлага хангаагүй барилга байгууламж ихээр баригдах нөхцөл байдал үүсдэг байна.	

					Манай улс Дэлхийн банкны судалгаагаар бизнес эрхлэх таатай орчинг бүрдүүлээгүй, бизнес эрхлэгчдийг хангалттай дэмждэггүй, барилгын салбарт үйл ажиллагаа эрхлэхэд төрөөс зөвшөөрөл авах шат дамжлага, хүнд суртал ихтэй гэж дүгнэсэн байна. Барилгын зөвшөөрөл авах үзүүлэлтээр дэлхийн 185 орноос 121 дүгээр байр, Зүүн Ази, Номхон Далайн бүсийн 24 орноос энэ үзүүлэлтээр 21 дүгээр байрт тус тус орж байгаа нь барилгын зөвшөөрөл олгох асуудлыг эргэж харах, өөрчлөх шаардлага гарсан. Түүнчлэн барилгын салбарт эрхлэх үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг олон шат дамжлага дамжуулан олгодог хэдий ч тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн хүлээх хариуцлагыг тусгайлан зохицуулаагүй. Мөн барилгын үйл ажиллагаа хууль зөрчсөн тохиолдолд хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг л түдгэлзүүлэх, цуцлах арга хэмжээ авч, гомдлын шаардлагыг төдийлөн барагдуулахгүй байна. Барилга байгууламжийн захиалагч, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч талуудын эрх үүрэг, хариуцлага тодорхойгүйгээс барилгын ажилд тавих хяналт хангалтгүй хийгдэх нөхцөл байдал үүсч байгаа зэрэг үндэслэл, шаардлага нь Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах нөхцөлийг бүрдүүлсэн. Иймд Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр УИХ-аар батлагдсантай холбогдуулан дүрэм, журмыг шинэчлэн батлуулахаар боловсруулж байна. Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар 5 дүрэм шинэчлэн баталсан.
3.	Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах	3.1.Хяналт шалгалтын ажлын 2016 оны төлөвлөгөө /төлөвлөгөөт/-г цахим хуудсандаа байршуулах	Жилийн турш	ЭБАТ, Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн	Барилга, хот байгуулалтын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын 2016 оны үйл ажиллагааны календарчилсан төлөвлөгөөг яамны /mcud.gov.mn/ цахим хуудасны Ил тод байдал цэсний үйл ажиллагааны ил тод байдал буланд, /intranet.gov.mn/ Удирдлагын цогц систем буюу “Абле” байгууллагын дотоод програмын файлын санд “Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар” гэсэн хавтас нээж календарчилсан төлөвлөгөөг байршуулсан.

		3.2. Хийсэн хяналт шалгалтынхаа дүнг олон нийтэд мэдээлэх /цахим хуудсаар, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн байх/	Жилийн турш	ЭБАТ, Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн	Барилга, хот байгуулалтын яамны Хэрэглэгчийн үнэлгээний тайланг /intranet.gov.mn/ Удирдлагын цогц систем буюу “Абле” байгууллагын дотоод програмд байршуулсан.
		3.3.Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ /дүгнэлт, акт, зөвлөмж гаргах, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авсан байдал/-ний үр дүнгийн талаар цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх	Жилийн турш	ЭБАТ, Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн	Яамны дотоод бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагаанд улирал бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт, санал, зөвлөмж гаргадаг ба хяналт шалгалт хийсэн ажлын үр дүнгийн талаар яамны ажилтнуудад тухай бүр мэдээлэл хийж ажилладаг.
4.	Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх /цахим хуудсаараа	4.1. Тухайн жилийн төсөв	1 дүгээр сарын 10-ны дотор	СЭЗХ	Тухайн жилийн төсвийг http://mcud.gov.mn/ сайтын ил тод байдал хэсэгт байршуулсан.
		4.2. Өмнөх оны төсвийн гүйцэтгэл	4 дүгээр сарын 1-ний дотор	СЭЗХ	Өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг http://info.shilendans.gov.mn сайтад бүтэн жилээр оруулах мэдээлэлд байршуулсан.
		4.3. Сарын төсвийн гүйцэтгэл	дараа сарын 8-ны дотор	СЭЗХ	Сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг http://info.shilendans.gov.mn сайтад сар бүр оруулах мэдээлэлд байршуулсан.
		4.4. Улирлын төсвийн гүйцэтгэл	дараа сарын 8-ны дотор	СЭЗХ	Улирлын төсвийн гүйцэтгэлийн мэдээг http://info.shilendans.gov.mn сайтад улирал бүр оруулах мэдээлэлд байршуулсан.
		4.5. Хагас жилийн төсвийн гүйцэтгэ	8 дугаар сарын 15-ны дотор	СЭЗХ	Хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг http://info.shilendans.gov.mn сайтад хагас жилээр оруулах мэдээлэлд байршуулсан.
		4.6. Хагас жилийн санхүүгийн тайлан	8 дугаар сарын 15-ны дотор	СЭЗХ	Хагас жилийн санхүүгийн тайланг http://info.shilendans.gov.mn сайтад хагас жилээр оруулах мэдээлэлд байршуулсан.
		4.7. Дараа жилийн төсвийн төсөл	9 дүгээр сарын 15-ны дотор	СЭЗХ	Дараа жилийн төсвийн төслийг http://mcud.gov.mn/ сайтын ил тод байдал хэсэгт байршуулсан.
		4.8. Жилийн эцсийн санхүүгийн тайлан	4 дүгээр сарын 25-ны дотор	СЭЗХ	Жилийн эцсийн санхүүгийн тайланг http://mcud.gov.mn/ сайтын ил тод байдал хэсэгт байршуулсан.
		4.9. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт	4 дүгээр сарын 25-ны дотор	СЭЗХ	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт http://mcud.gov.mn/ сайтын ил тод байдал хэсэгт байршуулсан.
		4.10. Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	7 дугаар сарын 1-ний дотор	СЭЗХ	Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар http://mcud.gov.mn/ сайтын ил тод байдал хэсэгт байршуулсан.
		4.11. Төсвийн хэмнэлт, хэлтрэлт, түүний шалтгааны тайлбар	улирал бүр	СЭЗХ	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт shilendans.gov.mn сайтад сар, улирал бүрт оруулах

					мэдээлэлд байршуулсан
		4.12. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	өөрчлөлт орсноос хойш ажлын 7 хоногийн дотор	СЭЗХ	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг http://mcud.gov.mn/ сайтын ил тод байдал хэсэгт байршуулсан.
		4.13. Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгох /татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээлэл/		СЭЗХ	Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгох /татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээллийг http://info.shilendans.gov.mn сайтад сар бүр оруулах мэдээлэлд байршуулсан.
		4.14. Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт	өөрчлөлт орсноос хойш 7 хоногийн дотор	СЭЗХ	Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд өөрчлөлт ороогүй талаар http://info.shilendans.gov.mn сайтад сар бүр оруулах мэдээлэлд байршуулсан.
		4.15. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт	гүйлгээ хийснээс хойш 7 хоногийн дотор	СЭЗХ	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт shilendans.gov.mn сайтад тухай бүрт нь байршуулсан.
		4.16. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт	өөрчлөлт орсноос хойш 7 хоногийн дотор	СЭЗХ	Засгийн газрын 2016 оны 13 дугаар тогтоолоор яамны бүтэц, орон тоо шинэчлэн батлагдаж, Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны Б/122 дугаар тушаалаар газар, хэлтсийн чиг үүрэг, ажлын байрыг шинэчлэн баталсан.
		4.17. бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	батлагдсанаас хойш 7 хоногийн дотор	СЭЗХ	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг shilendans.gov.mn сайтад тухай бүрт нь оруулах мэдээлэлд байршуулсан
		4.18. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалт/ тухайн этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт/-ыг цахим хуудсандаа байршуулах	Тухай бүр	СЭЗХ	Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг http://mcud.gov.mn/ сайтын ил тод байдал хэсэгт байршуулсан.
		4.19. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл	Тухай бүр	СЭЗХ	
5.	Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах,	5.1. Тухайн байгууллагаас олгож буй зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийн жагсаалтыг гаргаж цахим хуудсандаа байршуулах	Жилийн турш	ЭБАТ, Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн	

	олон нийтэд танилцах боломжоор хангах	5.2.Дээрх зөвшөөрлийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмыг цахим хуудсандаа байршуулах	Жилийн турш	ЭБАТ, Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн	
		5.3.Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах	Жилийн турш	ЭБАТ, Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн	
		5.4.Салбарын хууль тогтоомжийг судлан үзэж тус яаманд бүртгэл хөтлөхөөр тусгагдсан асуудлын жагсаалтыг гаргах, нууцад хамаарахаас бусад бүртгэлийн талаарх мэдээллийг цахим хуудсанд байршуулах	Жилийн турш	ЭБАТ, Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн	
6.	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах	6.1.Сул орон тооны зарыг цахим хуудсандаа байршуулах /тухай бүр шинэчилсэн/	Жилийн турш	ЭБАТ, Хүний нөөц	Яамны зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдсөнтэй холбогдуулан УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан ”Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын дагуу ажлын байрны сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэн Төрийн албаны зөвлөлөөс дүгнэлт гарган нэр дэвшүүлсний дагуу албан тушаалд нь томилон ажиллаж байна. Тус яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл ажлын байрны сул орон тоо гарах бүрт захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлж www.csc.gov.mn сайтболон яамны цахим хуудаст байршуулж, зохих журмын дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулж байна. Яамны зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдсөнтэй холбогдуулан 2 газрын даргыг, 2 мэргэжилтэнг Төрийн албаны зөвлөлөөс дүгнэлт гарган нэр дэшүүлэн зохих журмын дагуу албан тушаалд нь томилохоор төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн байгаа. 1 газрын дарга 1 мэргэжилтэнг Төрийн албаны зөвлөлөөс дүгнэлт гарган нэр дэшүүлэн зохих журмын дагуу албан тушаалд нь томилон ажиллуулж байна. Удирдах ажилтны судалгааг Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн маягтын дагуу гаргаж сонгон шалгаруулах болон томилуулах зэрэг асуудлыг зохион байгуулахаар Төрийн албаны зөвлөлд хүргүүлэхээр ажиллаж байна.
		6.2.Сонгон шалгаруулалт явуулах талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарласан байх	Жилийн турш	ЭБАТ, Хүний нөөц	

7.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах	7.1.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудсандаа байршуулах	<i>1 дүгээр сарын 10-ны дотор</i>	ХАА хариуцсан мэргэжилтэн, Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн	<i>Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг http://mcud.gov.mn ил тод байдал болон http://info.shilendans.gov.mn/ сайтын бүтэн жилээр оруулах мэдээлэлд байршуулсан.</i>
		7.2.Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам /тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт/,тендерийн урилгыг цахим хуудсандаа байршуулсан байх	<i>1 дүгээр сарын 10-ны дотор</i>	ХАА хариуцсан мэргэжилтэн, Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн	Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам /тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт/, тендерийн урилгыг https://e-procurement.mof.gov.mn/ сайтад байршуулсан.
		7.3.Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг цахим хуудсанд байршуулах	<i>1 дүгээр сарын 10-ны дотор</i>	ХАА хариуцсан мэргэжилтэн, Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн	Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг http://mcud.gov.mn сайтын ил тод байдал болон http://info.shilendans.gov.mn/ сайтын сар бүр оруулах мэдээлэлд байршуулсан.
		7.4. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг цахим хуудсандаа байршуулах	<i>1 дүгээр сарын 10-ны дотор</i>	ХАА хариуцсан мэргэжилтэн, Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэрийг http://info.shilendans.gov.mn/ сайтад байршуулсан.
		7.5. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсандаа байршуулах	<i>1 дүгээр сарын 10-ны дотор</i>	ХАА хариуцсан мэргэжилтэн, Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалт хийгдээгүй.
		7.6.Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байх	<i>1 дүгээр сарын 10-ны дотор</i>	ХАА хариуцсан мэргэжилтэн, Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн	Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан.
8.	Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох	8.1.Төрийн албан хаагч нэг бүрийн ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг баталж мөрдүүлсэн байх	Жилийн турш	Хүний нөөц	Засгийн газрын 2016 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн 81 дүгээр тогтоолоор “Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийг батлуулсан. Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 8 дугаар сарын 09-ний өдрийн Б/122 тоот тушаалаар яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн орон тоо, ажил,

					ажлын байр /албан тушаал/-ны жагсаалтыг шинэчлэн баталсан.Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6 Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 63 дугаар тушаалаар Яамны зохион байгуулалтын нэгжийн үйл ажиллагааны стратеги, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан газар хэлтсүүдээс нийт албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг татан авч, 66 ажлын байр/албан тушаал/-ны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж ажлын хэсгийн гишүүдийн саналыг тусган батлуулан мөрдөн ажиллаж байна.
		8.2.Хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа нээлттэй болгох	Жилийн турш	Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн	Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 8 дугаар сарын 09-ний өдрийн Б/122 тоот тушаалаар яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн орон тоо, ажил, ажлын байр /албан тушаал/-ны жагсаалтыг шинэчлэн батлан яамны цахим хуулсанд байршуулсан.
9.	Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах	9.1.Тодорхой төрлийн үйл ажиллагааны хэрэгжилт, явц байдалд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлсэн байх /1 ба түүнээс дээш/	Жилийн турш	ТЗУГ, Бодлогын газрууд	“Геодези, зураг зүйн салбарт мөрдөгдөж байгаа норм, дүрэмд үзлэг хийж, техникийн түвшинг тогтоох” зөвлөх үйлчилгээг Ц.Дашзэвгэ ахлагчтай судлаачдын багаар гүйцэтгүүлж байна.
		9.2.Төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнгийн талаарх мэдээллийг тайландаа тусгасан байх	Жилийн турш	ТЗУГ, Бодлогын газрууд	Архитекторын болон хот төлөвлөлтийн орон тооны бус мэргэжлийн зөвлөл, Барилгын салбарын хот төлөвлөлт, архитекторын чиглэлийн мэргэжилтнийг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх сургалтын чиг үүргийг “Монголын архитекторуудын эвлэл” төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхээр Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 169, 170 дугаар тушаал батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
		9.3.Хэрэгжүүлсэн ажил, хамтын ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаараа мэдээлсэн байх	Жилийн турш	Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн	“Монголын архитекторуудын эвлэл”-ийн 65 жилийн ой, Ерөнхий сайд төрийн бус байгууллагуудтай хийсэн уулзалтаар Барилга, хот байгуулалтын сайд хамтран ажиллах талаар мэдээлсэн. http://mcud.gov.mn/2016/08/08/%D0%B1%D1%85%D0%B1-%D1%8B%D0%BD-%D1%81%D0%B0%D0%B9%D0%B4-%D0%B3-%D0%BC%D3%A9%D0%BD%D1%85%D0%B1%D0%B0%D1%8F%D1%80-%D0%BC%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB%D1%8B%D0%BD-%D0%B1%D0%B0%D1%80%D0%B8%D0%BB%D0%B3/

					http://mcud.gov.mn/2016/09/02/%D0%B1%D0%B0%D1%80%D0%B8%D0%BB%D0%B3%D0%B0-%D1%85%D0%BE%D1%82-%D0%B1%D0%B0%D0%B9%D0%B3%D1%83%D1%83%D0%BB%D0%B0%D0%BB%D1%82%D1%8B%D0%BD-%D1%81%D0%B0%D0%B9%D0%B4-%D1%81%D0%B0%D0%BB%D0%B1%D0%B0%D1%80/
10.	Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтантай байх	10.1.Эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-ыг томилсон байх, урамшуулал өгдөг эсэх	Жилийн турш	Төрийн нарийн бичгийн дарга	Эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан албан хаагч ажлаас чөлөөлөгдсөнтэй холбогдуулан 2016 оны 6/15 тушаалаар Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн О.Нямхүүг томилж, албан тушаалын цалингийн 20 хувиар урамшуулал олгосон. Бүтэц чиг үүрэг өөрчлөгдсөнтэй холбогдуулан Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 6/155 дугаар тушаалаар Хуулийн хэлтсийн дарга С.Амартүвшинг эрх бүхий албан тушаалтнаар томилж, сар бүр албан тушаалын цалингийн нэмэгдэл олгож байна.
		10.2.ЭБАТ-ын гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусгасан байх	Жилийн турш	Хүний нөөц	Эрх бүхий албан тушаалтны чиг үүргийг Хуулийн хэлтсийн мэргэжилтний ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээнд тусгасан.
		10.3.Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад ЭБАТ-ыг хамруулах, АТГ-аас арга зүйн зөвлөгөө авч ажиллах	Жилийн турш	ЭБАТ, ТЗУГ	Авлигатай тэмцэх газарт Авлигын эсрэг хууль тогтоомжийн сургалтыг тус яаман дээр зохион байгуулах хүсэлт хүргүүлсэн.
11.	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх	11.1.Ёс зүйн дүрмийн төсөлд Авлигатай тэмцэх газраас өгсөн саналыг тусгасан байх	Жилийн турш	Ёс зүйн хорооны нарийн бичиг	Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2013 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн 62 дугаар тушаалаар Ёс зүйн хороог байгуулсан. Барилга, хот байгуулалтын яамны “Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний дүрэм”, “Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”-ыг Яамны Төрийн нарийн бичгийн даргын 2013 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн 143 дугаар тушаалаар АТГ-аас өгсөн саналыг тусган батлан мөрдөж ажиллаж байна.
		11.2.Ёс зүйн дүрмийг албан хаагч бүрт нэг бүрчлэн танилцуулахдаа гарын үсэг зуруулах бүртгэл хөтлөх /бүртгэлийн жилийн эцэст АТГ-д тайланд хавсарган хүргэх/	Жилийн турш	Ёс зүйн хорооны нарийн бичиг	Батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний дүрэм”, “Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”-ыг нийт албан хаагчдад танилцуулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

		11.3.Зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх	Жилийн турш	Байгууллага	Зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах тухай Барилга, хот байгуулалтын яамны цахим хуудас болох http://mcud.gov.mn -д байршуулан хариуцах эзэн утасны дугаар гэх мэт мэдээлэлийг байршуулсан болно. Мөн яамны дотоод мэдээллийн системд байршуулсан.
		11.4.Зөрчил үүссэн буюу үүсч болзошгүй тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээ /Зөвлөмж/-г авах	Жилийн турш	Ажлын хэсэг, үнэлгээний хороо, комиссын гишүүд /нарийн бичиг/	Зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар албан хаагчдад дотоод сүлжээгээр зөвлөмж, мэдээллийг өгч ажиллаж байна.
		11.5.Зөрчил илэрсэн тохиолдолд хуульд заасан хариуцлагыг хүлээлгэсэн байх	Жилийн турш	Төрийн нарийн бичгийн дарга	Өнгөрсөн хугацаанд ёс зүйн зөрчлийн чиглэлээр хандсан өргөдөл, гомдол ирээгүй байна.
		11.6.Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хамт олонд мэдээлсэн байх	10-р сар	Ёс зүйн хорооны нарийн бичиг	Барилга, хот байгуулалтын яамны “Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний дүрэм”, “Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”-ын хэрэгжилтийг хамт олонд мэдээлсэн болно.
12.	Давхар ажил эрхлэх боломж-той эсэхийг шийдвэрлэх	12.1.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, салбарын хууль тогтоомж, олон улсын гэрээ конвенц, Засгийн газрын шийдвэр зэргийг судлан үзэж яамны ажилтан албан хаагчид давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргах, албан хаагчдад танилцуулсан байх, хэрхэн танилцуулсан тухай нотлох баримтыг АТГ-д тайланд хавсарган хүргүүлэх	Тухай бүр	ЭБАТ, Хүний нөөц	Төрийн албан тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.6- дахь заалт, болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 -20 дугаар зүйлд заасан давхар ажил эрхлэлттэй холбогдсон хязгаарлалтыг яамны албан хаагчдад танилцуулсан.
		12.2.Яамны албан хаагчдын давхар ажил эрхлэлтийн талаарх судалгаа гаргах, давхар ажил эрхлэх тохиолдолд зөвшөөрөл олгох эсэх шийдвэрийг гаргах	Тухай бүр	ЭБАТ, Хүний нөөц	Давхар ажил эрхлэлтийн судалгааг хавсаргав.
13.	Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах	13.1.Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг цахим хуудсаараа бүрдүүлэх, тусгай цонх линктэй болох	Тухай бүр	Хүний нөөц, Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн	Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор Барилга, хот байгуулалтын Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаал шийдвэрийг цахим хуудас болон Удирдлагын цогц систем буюу “Абле” байгууллагын дотоод програмд байршуулж, улирдлагуудын шийдвэр, үүрэг даалгаврын хэрэгжилтийн талаар мэдээлэл солилцох, хяналт

					тавих, зөвлөгөө өгөх зэрэг боломжийг бүрдүүлэн удирдлагын арга барилыг шинэлэг хэлбэрээр нэвтрүүлсэн.
		13.2.Сайдаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад тушаалыг тухай бүр цахим хуудсанд байршуулах	Тухай бүр	Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн	Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгосон тушаалыг тухай бүр нь www.barilga.gov.mn сайтад байршуулж байна.
		13.3.ТНБД-ийн гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад тушаалыг тухай бүр цахим хуудсанд байршуулах	Тухай бүр	Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн	Төрийн нарийн бичгийн даргын “б” тушаалаас бусад тушаалыг цахим хуудсанд байршуулсан. http://www.barilga.gov.mn/?page=custom&module=news&id=0714b652-10ae-4c8d-a46e-25d200e88499
		13.4.Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж /хуульчилсан акт/, дүрэм, журам, зааврыг цахим хуудсандаа байршуулах	Тухай бүр	Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн	Барилга, хот байгуулалтын салбарын хууль тогтоомжийг яамны цахим хуудас болон www.barilga.gov.mn сайтад байршуулсан.
		13.5.Үйлчлүүлэгчээс авч буй бүх төрлийн төлбөр, хураамжийг цахим хуудсандаа байршуулах	Тухай бүр	Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн	Яам иргэдээс ямар нэгэн төлбөр, хураамж авдаггүй болно.
14.	Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах	14.1.Салбарын болон бусад үйл ажиллагаанд мөрдөж буй хууль тогтоомжийг судлан үзэж БХБЯ-ны эрхлэх асуудлын хүрээг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон цахим хуудсаараа иргэдэд мэдээлж, сурталчлах	Тухай бүр	Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн	Барилга, хот байгуулалтын яамны эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээ, мэдээллийг яамны /mcud.gov.mn/ цахим хуудас, “Барилгын мэдээлэл” сэтгүүл болон бусад мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлж, сурталчилж байна.
		14.2.Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байх (утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр)	Тухай бүр	Өргөдөл, гомдол, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн	Барилга, хот байгуулалтын яаманд 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар өргөдөл 89, санал 1, хүсэлт 73, мэдээлэл 1 ирсэн байна. Үүнийг илгээгчийн төрлөөр нь авч үзвэл иргэнээс 115, ажилтнаас 17, хамт олноос 23, байгууллагаас 6 ирсэн байна. Шийдвэрлэлтийн байдал 91.5%-тай байна. Үлдсэн 8.5% нь шийдвэрлэх шатанд байна. Өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийг бичгээр өдөр бүр тогтмол хүлээн авч байна.
		14.3.Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах	Тухай бүр	Өргөдөл, гомдол, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн	Төрийн захиргааны удирдлагын газарт Өргөдөл, гомдол, санал хүсэлт хариуцсан ахлах мэргэжилтэн ажилуулж байна. Харилцах утас мэдээллийг яамны цахим хуудас болон бусад мэдээллийн сайтуудад байршуулсан. Иргэдийг хүлээж авах уулзалтын цагийн хуваарийг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан

					хэрэгжүүлж ажиллаж байна.
		14.4.Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлсэн байх	Тухай бүр	Өргөдөл, гомдол, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн	Байгууллагын вэб сайтан дээр улирал тутам дүн мэдээг тавьж байна. Мөн утсаар өргөдөл, гомдол, хүсэлт мэдээллийг хүлээн авч байгаа болно.
15.	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах	15.1.Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах, уг жагсаалтыг гаргахдаа тодорхой судалгаа, шинжилгээнд тулгуурлах	Тухай бүр	ЭБАТ, Хүний нөөц	
		15.2. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /хүнд суртал, чирэгдлийг багасгах, сөрөг үзэгдлийг хаах, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянах, мэдэгдэл гаргах, албан хаагчийн ажлын байрыг сэлгүүлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг хэрхэн зохион байгуулсан г.м/	Тухай бүр	Байгууллагын хэмжээнд	Үнэлгээний хороо томилогдсон тухай бүрт нь ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл гаргуулан авч байна. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох асуудлаар урьдчилсан дүгнэлт гаргах ажлын хэсгийн гишүүдээр хурал бүрийн өмнө ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл гаргуулан авч байна.
		15.3. АТГ-ын захиалгаар “Монгол улсад ил тод байдлыг бэхжүүлэх нь” төслийн санхүүжилтээр хийгдсэн “Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдлын судалгаа”-ны дүнг танилцуулах уулзалт, хэлэлцүүлгийн АТГ-тай хамтран зохион байгуулах	5-р сард	АТГ-н мэргэжилтэн Яамны ЭБАТ	
16.	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх	16.1.Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн Зөвлөмжийг хүлээн авч, биелэлтийг зохион байгуулж ажиллах	Тухай бүр	ЭБАТ	Авлигатай тэмцэх газраас “Гомдол мэдээллийн мөрөөр холбогдох арга хэмжээг авхуулах тухай” 2016 оны 01/1237 тоот албан бичиг ирүүлсэн. Тусгай зөвшөөрөлд хүндрэлтэй олгож байгаа, хуулиас гадуур шаардлага байна гэснийг судлан үзэж холбогдох суурь нөхцөл шаардлагыг шинэчлэн боловсруулан “Барилгын хөгжлийн төв”-д салбарын аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын төлөөллөөр хэлэлцүүлсэн.
		16.2. АТГ-ын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар хүргүүлсэн мэдэгдлийн мөрөөр холбогдох арга хэмжээ авах, хариу мэдэгдэх	Тухай бүр	ЭБАТ	Ийм мэдэгдэл ирээгүй.
		16.3. АТГ-аас зөрчил арилгуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлтийг	Тухай бүр	ЭБАТ	Ийм албан бичиг ирээгүй.

		хангах, хугацаанд нь хариу өгөх			
		16.4. АТГ-аас хариуцлага тооцож, арга хэмжээ авахуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлтийг хангах, хариу өгөх	Тухай бүр	ЭБАТ	Ийм албан бичиг ирээгүй.
		16.5. Авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн дүрэм, журам, заавар, шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгосон эсэх	Тухай бүр	ЭБАТ, ХШҮДАХэлтэс ийн дарга	Ийм албан бичиг ирээгүй.
		16.6. АТГ-ын даргын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Албан тушаал-тан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ыг хэрэгжүүлж ажиллах	Тухай бүр	ЭБАТ, Хүний нөөц	Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Э.Дондмаа нарын 7 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулсаныг Төрийн албаны зөвлөлөөс хүчингүйд тооцох, тушаал шийдвэрийг хүчингүй болгох чиглэл ирсэний дагуу шийдвэрийг хүчингүй болгосон. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн Ц.Борд албан үүргээ хугацаанд биелүүлээгүй тул 3 сарын албан тушаалын цалингийн 20 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан. Энэ талаар яамны мэдээллийн цаг арга хэмжээн дээр өөрөө мэдэгдэл хийлгэсэн.
Хоёр. Авлигатай тэмцэх санал, санаачилга					
17.	Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх	17.1.Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хувийг АТГ-т хүргүүлэх	2 сард	ЭБАТ, ТНБД	Барилга, хот байгуулалтын яамны авлигын эсрэг үйл ажиллагааны 2016 оны төлөвлөгөөг Авлигатай тэмцэх газарт хянуулж баталсан. хувийг АТГ-т хүргүүлсэн.
		17.2.Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг цаг, хугацаандаа хэрэгжүүлэх	Жилдээ	ЭБАТ	Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг цаг, хугацаандаа хэрэгжүүлж ажиллаж байна.
		17.3.Хэрэгжилтийн тайланг тогтсон хугацаа хүргүүлэх	11.15-ны дотор	ЭБАТ	Хэрэгжилтийн тайланг тогтсон хугацаанд хүргүүлсэн.
		17.4.Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, ололт амжилт, хүрсэн үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын саналыг тайланд тусган боловсруулж хүргүүлэх	11.15-ны дотор	ЭБАТ, Газрын дарга нар	Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, ололт амжилт, хүрсэн үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын саналыг тайланд тусган боловсруулж хүргүүлэх
18.	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт	18.1.Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга /уриа, уриалга, мэдэгдэл, амлалт г.м/-д нэгдэх	Жилийн турш	ТЗУГ	
		18.3.Авлигын эсрэг арга хэмжээнд зориулан тусгайлан хөрөнгө гаргасан эсэх /зарцуулалт/	Жилийн турш	ТЗУГ	

19.	Албан хаагчдын шударга байдал ба түүнийг нэмэг-дүүлэх	19.1.Албан тушаалтан, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах - Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний талаар сургалт зохион байгуулах; - Авлигыг үл тэвчих талаар тус яам болон харьяа байгууллагуудад сургалт зохион байгуулах; - Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэх талаар албан хаагчдад танилцуулга хийж сургалт зохион байгуулах	Жилийн турш	Ёс зүйн хорооны нарийн бичиг, Хүний нөөц, Сургалт хариуцсан мэргэжилтэн, ЭБАТ	- “Яамны дотоод бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааны төлөвлөлт ба хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам”-ыг шинэчлэн боловсруулж, яамны Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 26 тоот тушаалаар батлуулан ажиллаж байна. - Албан хаагчдын үр дүнгийн гэрээний биелэлтийг улирал тутам дүгнэж ажлын үр дүнгээр урамшуулал олгож ирсэн.
		19.2.Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авсан арга хэмжээ	Жилийн турш	Хүний нөөц	Албан хаагчдын үр дүнгийн гэрээг улирал бүр дүгнэж байна.
		19.3.Байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын хүрээнд илрүүлсэн зөрчил, түүний мөрөөр авсан арга хэмжээ тайланд тусгах, нотлох баримтыг тайланд хавсаргах	11.15-ны дотор	ХШҮДАХ	Байхгүй.
		19.4.Бусад байгууллага, иргэдийн гомдлоор илэрсэн зөрчил, авсан арга хэмжээг тайланд тусгах, нотлох баримтыг тайланд хавсаргах	11.15-ны дотор	ХШҮДАХ, өргөдөл гомдол, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн	Байхгүй.

Боловсруулсан:

ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

С.АМАРТҮВШИН

Хянасан:

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.МАГНАЙСҮРЭН